



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/09

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1, 26.1.4, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1-д заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Тус аймгийн Баян-Овоо сумын Сүмбэр, Дэлгэрхаан баг, Норовлин сумын Баян-Өлзийт, Ангирт баг, Батноров сумын нутагт гарсан мал амьтны гоц халдварт "шүлхий" өвчнөөс урьдчилан сэргийлэх, цомхотгон дарах үйл ажиллагаанд гарсан зардлыг олгосугай.

Хоёр. Сумдын нэр, зардлын төрөл, мөнгөн дүнг хавсралтаар баталсугай.

Гурав. Мал амьтны гоц халдварт "Шүлхий" өвчинтэй тэмцэхэд шаардагдах 13033900 /Арван гурван сая гучин гурван мянга есөн зуун/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн малын гоц халдварт өвчинтэй тэмцэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 424

02
Аймгийн Засаг даргын 2017 оны
дугаар сарын 02 өдрийн 1169
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН НЭР, ТӨРӨЛ

д/д	Байгууллагын нэрс	Шатах тослох материал	Хоол хүнс	Эм тариа	Ариутгал Халдваргүйт гэлийн бодис	Халдвар хамгааллын хувцас	Холбооны зардал	Дүн /төгрөг/
1	Баян-Овоо	2000000	1000000					3000000
2	Норовлин	1500000	500000					2000000
3	Батноров	1000000						1000000
4	Онцгой комисс	1583900					150000	1733900
5	ХААГазар			300000	3500000	1500000		5300000
	Бүгд	6083900	1500000	300000	3500000	1500000	150000	13033900